



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 91

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4” төслийн нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 19 нэрийн, нийт 12,185,486.00 (арван хоёр сая нэг зуун наян таван мянга дөрвөн зуун наян зургаан) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж үнийг нэгдүгээр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоож, 13 нэрийн нийт 20,275,139.51 (хорин сая хоёр зуун далан таван мянга нэг зуун гучин есөн төгрөг тавин нэгэн мөнгө) төгрөгийн балансын үнэ, 9,472,771.88 (есөн сая дөрвөн зуун далан хоёр мянга долоон зуун далан нэгэн төгрөг наян найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хоёрдугаар хавсралтад заасны дагуу тус тус “Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр” 3843/3844-МОН төслийн нэгжид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4(5)” төслийн нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 64,341,432.00 (жаран дөрвөн сая гурван зуун дөчин нэгэн мянга дөрвөн зуун гучин хоёр) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг гуравдугаар хавсралтад заасны дагуу ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

3. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Эрдэмбилэг, Нэгдсэн төслийн зохицуулагч А.Мөнхтайван, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Д.Ганболд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

3.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

3.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

132001600

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн
1 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

"ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ ХӨТӨЛБӨР -4" МОН-0236 ТӨСЛИЙН НЭГЖИД БҮРТГЭЛТЭЙ
АШИГЛАХ ХУГАЦАА, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ "ЭМЗЭГ БҮЛГИЙН ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР" 3843/3844-МОН ТӨСЛИЙН НЭГЖИД
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Эд хөрөнгийн нэр, марк	Ашиглалтанд орсон он	Тоо хэмжээ	Нэгж үнэ (төгрөг)	Балансын болон хуримтлагдсан элэгдэлийн үнэ	Шинэчлэн тогтоосон үнэ, хугацаа		Нийт үнэ (төгрөг)
						Цаашид ашиглах жил	Нэгж үнэ (төгрөг)	
1	Дугуйтай тумбочка Be M3	6/16/2011	5	123,200.00	616,000.00	3	50,000.00	250,000.00
2	Агааржуулагч BSB AC 09GSW	2011-06-09	2	549,900.00	1,099,800.00	3	100,000.00	200,000.00
3	Хөргөгч Toshiba H15PT1	2011-06-09	1	419,900.00	419,900.00	3	150,000.00	150,000.00
4	Камер /Канон/ EOS 5500 18-55IS , 18mp, 22.3x14.3mm, CMOS, Digic4,	2011-06-09	1	1,477,500.00	1,477,500.00	3	500,000.00	500,000.00
5	Бичгийн шүүгээ	1/22/2010	1	245,364.00	245,364.00	3	80,000.00	80,000.00
6	Булангийн шүүгээ	2008/06/23	4	149,909.00	599,636.00	3	50,000.00	200,000.00
7	Сейф	2008/06/25	1	254,455.00	254,455.00	3	100,000.00	100,000.00
8	Төмөр шүүгээ, шилтэй	2008/06/23	2	222,636.00	445,272.00	3	80,000.00	160,000.00
9	Тумбочка	2008/06/23	5	181,727.00	908,635.00	3	50,000.00	250,000.00
10	Хувцасны шакаф	2008/06/23	1	236,272.00	236,272.00	3	100,000.00	100,000.00
11	Хурлын ширээ	2008/06/23	1	263,546.00	263,546.00	3	100,000.00	100,000.00
12	Хурлын ширээ	2009/05/25	1	207,317.00	207,317.00	3	100,000.00	100,000.00
13	Шилэн хана, хаалга	2009/05/14	1	836,364.00	836,364.00	3	300,000.00	300,000.00
14	Ширээний хаалт	2008/06/23	9	99,909.00	899,181.00	3	40,000.00	360,000.00
15	Сандаг	6/23/2008	18	60,009.00	1,080,162.00	3	20,000.00	360,000.00
16	Диктофон	2009/04/14	1	227,182.00	227,182.00	3	50,000.00	50,000.00
17	Прожекторын дэлгэц	2008/07/04	1	209,000.00	209,000.00	3	50,000.00	50,000.00
18	Халаагуур	2009/11/12	2	330,000.00	660,000.00	3	80,000.00	160,000.00
19	Прожектор Нес	5/15/2013	1	1,499,900.00	1,499,900.00	3	300,000.00	300,000.00
								3,770,000.00
						12,185,486.00		
						(арван хоёр сая нэг зуун наян таван мянга дөрвөн зуун наян зургаан төгрөг)		(гурван сая долоон зуун далан мянган төгрөг)

Нийт хөрөнгийн дүн

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны ... дугаар сарын ... ны өдрийн
... дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

"ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ ХӨТӨЛБӨР -4" МОН-0236 ТӨСЛИЙН НЭГЖИД БҮРТГЭЛТЭЙ "ЭМЗЭГ БҮЛГИЙН ИРГЭДИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР" 3843/3844-МОН
ТӨСЛИЙН НЭГЖИД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

1	Эд хөрөнгийн нэр, марк	Ашиглалтанд орсон он	Тоо хэмжээ (ширхэг)	Нэгж үнэ (төгрөг)	Нийт балансын хуучин үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Дугуйтай сандал C008-3TG	2012-01-05	4	137,500.00	550,000.00	536,250.00	13,750.00
2	Ширээ BE 120	2012-01-05	4	141,900.00	567,600.00	553,410.00	14,190.00
3	Шкаф РС	2012-02-09	1	579,506.78	579,506.78	560,189.89	19,316.89
4	Компьютерын кабинет BSB	2015-10-28	1	321,900.00	321,900.00	190,457.50	131,442.50
5	Үүдний халаалтын төхөөрөмж Орос	2015-11-24	1	480,000.00	480,000.00	280,000.00	200,000.00
6	Тог баригч UPS 9B1714A13035	2017-10-09	2	124,454.55	248,909.09	194,978.79	53,930.30
7	Хатуу диск Hard driver 1TB store	2017-10-09	3	170,363.67	511,091.00	400,354.62	110,736.38
8	Суурин компьютер Dell 3265-72T	2017-10-09	2	2,181,727.00	4,363,454.00	3,418,038.97	945,415.03
9	Суурин компьютер Dell 3888 i5 10th gen	2020-08-24	5	1,925,454.00	9,627,270.00	2,085,909.00	7,541,361.00
10	Тог баригч UPS pro1201	2020-08-20	7	199,909.09	1,399,363.64	303,196.00	1,096,167.64
11	Ус цэвэршүүлэгч	2021-01-18	1	580,000.00	580,000.00	87,000.00	493,000.00
12	Хар буйдан КСВ-М201	2013-05-03	2	303,050.00	606,100.00	500,032.50	106,067.50
13	Хар буйдан КСВ-М202	2013-05-03	1	439,945.00	439,945.00	362,954.63	76,990.38
			34		20,275,139.51	9,472,771.88	10,802,367.63
	Нийт хөрөнгийн дүн				(Хорин сая хоёр зуун далан таван мянга нэг зуун гучин есөн төгрөг тавин нэгэн мөнгө)	(есөн сая дөрвөн зуун далан хоёр мянга долоон зуун далан нэгэн төгрөг наян найман мөнгө)	(арван сая найман зуун хоёр мянга гурван зуун жаран долоон төгрөг жаран гурван мөнгө)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн
09 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт

"ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ ХӨТӨЛБӨР -4" МОН-0236 ТӨСЛИЙН НӨГЖИД БҮРТГЭЛТЭЙ
АВТОМАШИНЫ АШИГЛАХ ХУГАЦАА, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ, ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Балансын үнэ Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг)	Ашиглах хугацаа
1	Мөнгөлөг өнгөтэй TOYOTO LAND CRUSER-200 6635 УБК, арал № JTMCU09J104011319	2008/ 07.04	64,341,432.00	15,000,000.00	6
Нийт дүн			(жаран дөрвөн сая гурван зуун дөчин нэгэн мянга дөрвөн зуун гучин хоёр төгрөг)	(арван таван сая төгрөг)	